



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Хорооны 2014 оны 07 дугаар тогтоол  
болон уг тогтоолоор батлагдсан журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолын үндэслэх хэсгийг “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн” гэсний дараа “36.16” гэж нэмсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны тухай журам”-д доор дурьдсан агуулгатай дараах 9<sup>1</sup> дүгээр зүйлийг нэмсүгэй:

**1/ Ес<sup>1</sup>. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх тухай**

9.1<sup>1</sup>. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.16-д заасны дагуу брокерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий зохицуулалттай этгээд нь гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагааг Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

9.2<sup>1</sup>. Энэхүү журмын 9.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл хүсч буй зохицуулалттай этгээд нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

9.2.1<sup>1</sup>. 200.0 сая төгрөгөөс доошгүй хэмжээний хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байх;

9.2.2<sup>1</sup>. үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн бэк оффис /back office/-ийн програмтай байх ба тус програм нь гадаад улсын үнэт цаасны арилжаа эрхлэх, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагын болон кастодиан банкны системд нийцсэн, тухайн улсын хадгаламжийн байгууллагын дүрэм, журамд нийцүүлэн харилцагчийн хөрөнгийн бүртгэлийг хөтөлдөг байх;

9.2.3<sup>1</sup>. энэхүү журмын 9.2.2-д заасан програм нь харилцагч өөрийн данс дахь хөрөнгийн талаарх мэдээллийг цахим болон бусад хэлбэрээр авах боломжоор хангасан байх;

9.2.4<sup>1</sup>. харилцагчийн данс хариуцсан мэргэжилтэнтэй байх ба уг мэргэжилтэн нь үнэт цаасны төлбөр тооцоо, бүртгэлийн чиглэлээр үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй байх;

000184

9.2.5<sup>1</sup>. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36.8-д заасны дагуу харилцагчийн хөрөнгийг өөрийн хөрөнгөөс тусгаарлан харилцагч тус бүрээр тусгайлан, нэр төрлөөр нь балансын гадуур дэлгэрэнгүй бүртгэж байх; /Харилцагчийн гадаад улсын үнэт цаасны зах зээлээс үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгө, худалдан авсан үнэт цаас, түүнтэй холбоотой орлогыг тайлангийн тодруулгын “балансын гадуурх бүртгэлийн тодруулга” хэсэгт тусгана./

9.2.6<sup>1</sup>. гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах брокерийн үйл ажиллагаа эрхлэх тухай дотоод журмыг компанийн эрх бүхий этгээдээр батлуулсан байх;

9.2.7<sup>1</sup>. харилцагчийн мөнгөн хөрөнгийн бүртгэл, арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн ерөнхий мэдээллийг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлж байх.

9.3<sup>1</sup>. Энэхүү журмын 9.2-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан зохицуулалттай этгээдэд гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлахыг Хороо зөвшөөрнө.

9.4<sup>1</sup>. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах этгээд нь харилцагчийн захиалгыг биелүүлэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-36.15 дахь хэсгүүдийг мөрдөж ажиллана.

9.5<sup>1</sup>. Энэхүү журмын 9.1-д заасан үйл ажиллагааг Хорооны зөвшөөрөлгүй эрхэлсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.

9.6<sup>1</sup>. Энэхүү журмын 9.2-д заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй бол захиргааны хариуцлага ногдуулж, энэ журмын 9.1-д заасан зөвшөөрлийг хүчингүй болгоно.”.

2. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН